



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 07 дугаар сарын 29

Дугаар 17/03

Баян-Өндөр сум

Аймгийн 2023 оны төсвийн гүйцэтгэл
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймгийн 2023 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг 287,120,922.0 (Хоёр зуун наян долоон тэрбум нэг зуун хорин сая есөн зуун хорин хоёр мянга), зарлагын гүйцэтгэлийг 273,372,833.7 (Хоёр зуун далан гурван тэрбум гурван зуун далан хоёр сая найман зуун гучин гурван мянга долоон зуу), төсвийн хэмнэлтийг 13,748,088.3 (Арван гурван тэрбум долоон зуун дөчин найман сая наян найман мянга гурван зуу), давсан орлогыг 9,688,478.6 (Есөн тэрбум зургаан зуун наян найман сая дөрвөн зуун далан найман мянга зургаан зуу) төгрөгөөр тус тус баталсугай.

2.Төсвийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн зарцуулалтад тавих, хяналтыг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга (М.Түмэнжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ